



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03

Хэрлэн сум

**Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын
Өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус ажлын хэсэг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон аймгийн Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах ажлыг хариуцсугай.

2.Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Компьютер, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн Хууль эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл системчлэл дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Архивын тасгийн дарга Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

2.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан
Бодогч

Нийгмийн бодлогын хэлтсийн Соёлын үйл
ажиллагаа, биеийн тамир спортын бодлого
хариуцсан мэргэжилтэн

Дайчилгааны офицер

Аж ахуйн тасгийн дарга

3.Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг ажлын
хэсгийн нарийн бичгийн дарга (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах
мэргэжилтэн)-д, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн
дарга (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)-д тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН